



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлөөр олгосон эрх хасах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн 2019 оны 4 дүгээр сарын 09-ний 0141001 дугаартай шийтгэлийн хуудас, 2019 оны 4 дүгээр сарын 9-ний 02-18/57 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нүүр амны их эмч Түвшинтөрийн Юмчинсүрэнд ИЭ0014952 сери, 0014952 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг 2019 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс 3 сарын хугацаагаар хассугай.

2. Т.Юмчинсүрэнгийн эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрх хассантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг гурван сарын хугацаагаар хассан тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Амарсайхан/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо /Ч.Доржгүнсмаа/, Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс /Д.Хишигбаатар/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080838